

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймаг дахь Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/10/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Булган аймаг
2022 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХАА	Хөдөө аж ахуй

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

 БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР		БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА А.ГАНТӨМӨР ТАНАА
63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг, Утас: 7034-2580, Факс: 7034-2580		
2022.02.23 № 31.		
танай _____	-ны № _____	Т _____
Зөрчилгүй дүгнэлт		
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p> <p>Дүгнэлтийн үндэслэл</p> <p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p> <p>Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага</p> <p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p> <p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.</p> <p>Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага</p> <p>Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.</p> <p>Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.</p>		
D:/bichighereg/2022A4toot		
00602066?		

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

2.Аудит санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>80,027,182.15</u>	<u>77,061,002.15</u>
33	АВЛАГА	1,108,866.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	108,866.00	00.00
335	Бусад авлага	1,000,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	1,000,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	78,918,316.15	77,061,002.15
351	Түүхий эд материал	60,236,159.15	57,849,219.15
35110	Тусгай зориулалттай материал	60,236,159.15	57,849,219.15
354	Хангамжийн материал	18,282,157.00	19,211,783.00
35410	Бичиг хэргийн материал	1,865,560.00	1,968,960.00
35420	Аж ахуйн материал	5,517,855.00	4,136,955.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,520,000.00	1,545,000.00
35440	Түлш, шатах тослох материал	9,375,742.00	11,273,468.00
35470	Бусад хангамжийн материал	3,000.00	287,400.00
35600	Мал амьтад	400,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>748,663,964.10</u>	<u>696,521,923.94</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	748,663,964.10	696,521,923.94
392	Биет хөрөнгө	693,027,136.10	640,885,095.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	555,469,883.97	555,469,883.97
39202	Хуримтлагдсан элэгдэл	-51,124,186.37	-72,729,689.77
39203	Авто-тээврийн хэрэгсэл	158,845,523.00	158,845,523.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-34,726,476.68	-77,488,381.04
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	95,718,715.95	93,893,115.95
39206	Хуримтлагдсан элэгдэл	-40,766,250.39	-56,230,683.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,007,510.00	13,007,510.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,729,883.71	-9,630,408.31
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,372,000.00	43,872,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,039,699.67	-8,123,774.62
393	Биет бус хөрөнгө	55,636,828.00	55,636,828.00
39301	Программ хангамж	25,830,000.00	25,245,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-25,830,000.00	-25,245,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	55,636,828.00	55,636,828.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>828,691,146.25</u>	<u>773,582,926.09</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>828,691,146.25</u>	<u>773,582,926.09</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	828,691,146.25	773,582,926.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	438,496,996.60	438,496,996.60
51101	Өмч: - төрийн	438,496,996.60	438,496,996.60
512	Хуримтлагдсан үр дүн	120,626,213.99	65,517,993.83
51210	Өмнөх үеийн үр дүн	120,626,213.99	120,626,213.99
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-55,108,220.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	269,567,935.66	269,567,935.66
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>828,691,146.25</u>	<u>773,582,926.09</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	678,257,952.00	616,625,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	140,352,252.00	3,173,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	140,352,252.00	3,173,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	140,352,252.00	3,173,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	140,352,252.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	537,905,700.00	613,452,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,950,000.00	10,050,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	9,900,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	950,000.00	150,000.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	532,955,700.00	603,402,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	532,955,700.00	603,402,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	584,425,923.73	671,734,020.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	584,425,923.73	671,734,020.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	575,305,580.47	636,611,850.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	403,514,914.00	408,917,073.00
210101	Үндсэн цалин	361,382,797.00	319,839,408.00
210102	Нэмэгдэл	27,730,717.00	74,449,765.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,401,400.00	14,627,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,538,936.23	54,010,672.62
210201	Тэтгэврийн даатгал	46,136,983.07	37,803,006.58
210202	Тэтгэмжийн даатгал	1,390,786.21	4,058,025.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,092,467.63	3,289,480.70
210204	Ажилгүйдлийн даатгал	262,323.37	801,024.28
210205	Эрүүл мэндийн даатгал	2,656,375.95	8,059,135.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,142,314.67	36,477,100.00
210301	Гэрэл, цахилгаан	7,571,931.42	8,695,600.00
210302	Түлш, халаалт	29,570,383.25	27,781,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,997,514.84	21,424,114.00
210401	Бичиг хэрэг	1,197,640.00	3,694,300.00
210402	Тээвэр, шатахуун	6,160,402.00	8,077,774.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,409,989.84	2,430,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	712,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	229,483.00	276,500.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	6,232,140.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,679,900.00	4,582,200.00
210604	Урсгал засвар	1,679,900.00	4,582,200.00
2107	Томилолт, зочны зардал	2,726,500.00	4,839,100.00
210702	Дотоод албан томилолт	2,726,500.00	4,839,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,944,443.00	9,319,551.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,176,770.00	8,532,099.00
210803	Даатгалын үйлчилгээ	268,020.00	236,220.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	277,123.00	328,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00
210807	Газрын төлбөр	134,530.00	134,532.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,761,057.73	97,042,040.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	10,900,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	556,178.00	500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	57,204,879.73	85,642,040.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,120,343.26	35,122,169.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,438,500.00	21,107,100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,438,500.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	18,240,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	2,866,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,681,843.26	14,015,069.38
	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,681,843.26	14,015,069.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	93,832,028.27	-55,108,220.16
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	93,832,028.27	-55,108,220.16

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	438,496,996.60	269,567,935.66	120,626,213.99	828,691,146.25
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	438,496,996.60	269,567,935.66	120,626,213.99	828,691,146.25
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-55,108,220.16	-55,108,220.16
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	438,496,996.60	269,567,935.66	65,517,993.83	773,582,926.09

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	537,905,700.00	614,538,894.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	537,905,700.00	614,538,894.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,950,000.00	11,050,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	10,900,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	950,000.00	150,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	532,955,700.00	603,402,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	532,955,700.00	603,402,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	86,594.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	86,594.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	537,545,800.00	581,038,894.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	537,545,800.00	581,038,894.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	528,425,456.74	545,830,130.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	403,836,747.00	408,808,207.00
210101	Үндсэн цалин	359,755,893.53	319,730,542.00
210102	Нэмэгдэл	30,362,953.81	74,449,765.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,717,899.66	14,627,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,578,842.23	54,010,672.62
210201	Тэтгэврийн даатгал	46,176,889.07	37,803,006.58
210202	Тэтгэмжийн даатгал	1,390,786.21	4,058,025.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,092,467.63	3,289,480.70
210204	Ажилгүйдлийн даатгал	262,323.37	801,024.28
210205	Эрүүл мэндийн даатгал	2,656,375.95	8,059,135.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,905,873.67	38,652,600.00
210301	Гэрэл, цахилгаан	7,571,931.42	8,695,600.00
210302	Түлш, халаалт	35,333,942.25	29,957,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,560,972.84	14,195,800.00
210401	Бичиг хэрэг	1,960,500.00	2,384,200.00
210402	Тээвэр, шатахуун	8,000,000.00	7,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,403,989.84	2,430,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	1,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	196,483.00	580,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,315,900.00	4,604,200.00
210604	Урсгал засвар	2,315,900.00	4,604,200.00
2107	Томилолт, зочны зардал	2,726,500.00	4,839,100.00
210702	Дотоод албан томилолт	2,726,500.00	4,839,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,944,443.00	9,319,551.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,197,900.00	8,532,099.00
210803	Даатгалын үйлчилгээ	268,020.00	236,220.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	277,123.00	328,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00
210807	Газрын төлбөр	113,400.00	134,532.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,556,178.00	11,400,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.00	10,900,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	556,178.00	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,120,343.26	35,208,763.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,438,500.00	21,193,694.00

213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	86,594.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,438,500.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	18,240,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	2,866,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,681,843.26	14,015,069.38
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,681,843.26	14,015,069.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	359,900.00	33,500,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	359,900.00	33,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	359,900.00	33,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	359,900.00	33,500,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	359,900.00	33,500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-359,900.00	-33,500,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	578,402,300.00	569,988,894.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	578,402,300.00	569,988,894.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	543,399,400.00	534,930,130.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	413,969,200.00	408,808,207.00
210101	Үндсэн цалин	322,706,300.00	319,730,542.00
210102	Нэмэгдэл	75,929,300.00	74,449,765.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,333,600.00	14,627,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,290,800.00	54,010,672.62
210201	Тэтгэврийн даатгал	39,612,000.00	37,803,006.58
210202	Тэтгэмжийн даатгал	4,169,700.00	4,058,025.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,335,800.00	3,289,480.70
210204	Ажилгүйдлийн даатгал	833,900.00	801,024.28
210205	Эрүүл мэндийн даатгал	8,339,400.00	8,059,135.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,652,600.00	38,652,600.00
210301	Гэрэл, цахилгаан	8,695,600.00	8,695,600.00
210302	Түлш, халаалт	29,957,000.00	29,957,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,195,800.00	14,195,800.00
210401	Бичиг хэрэг	2,384,200.00	2,384,200.00
210402	Тээвэр, шатахуун	7,800,000.00	7,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,430,800.00	2,430,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	1,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	580,800.00	580,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,604,200.00	4,604,200.00
210604	Урсгал засвар	4,604,200.00	4,604,200.00
2107	Томилолт, зочны зардал	5,800,000.00	4,839,100.00
210702	Дотоод албан томилолт	5,800,000.00	4,839,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,386,800.00	9,319,551.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,597,200.00	8,532,099.00

210803	Даатгалын үйлчилгээ	238,300.00	236,220.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	328,700.00	328,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00
210807	Газрын төлбөр	134,600.00	134,532.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	11,400,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,900,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,002,900.00	21,193,694.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,002,900.00	21,193,694.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	86,594.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,136,200.00	18,240,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,866,700.00	2,866,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	35,000,000.00	33,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	35,000,000.00	33,500,000.00
223001	Бусад хөрөнгө	35,000,000.00	33,500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	613,402,300.00	603,488,894.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	613,402,300.00	603,402,300.00
132001	Орон нутгийн төсвөөс	613,402,300.00	603,402,300.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	86,594.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	86,594.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	40.00	40.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	36.00	35.00
620003	Үйлчлэх ажилтан	03.00	04.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,050,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,050,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,900,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,900,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,900,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	150,000.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,050,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,050,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,900,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	150,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймаг дахь Байгаль орчин, аялал жуулчлалын газар 2021 оны 12

дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, Орхон аймгийн төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган аймаг дахь Байгаль орчин, аялал жуулчлалын газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн ... дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Булган аймаг дахь Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь Нутаг дэвсгэртээ Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны мэдээллийн санг бүрдүүлэх, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргад байгаль орчны чиглэлээр бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх нь Байгаль орчин, аялал жуулчлалын газрын эрхэм зорилго мөн. Энэхүү эрхэм зорилгыг хангаж ажиллахын тулд дараах үндсэн зарчмыг үйл ажиллагаандаа эрхэмлэнэ.

2003 онд Газар, Байгаль орчны албаны бүтцэд өөрчлөлт орж аймгийн Засаг даргын 38-р захирамжаар Байгаль орчны алба болон үйл ажиллагаа явуулж байгаад, 2009 онд аймгийн Засаг даргын 51-р тоот захирамжаар Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Засгийн газрын 2013 оны 146 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын А/236 тоот захирамжаар Байгаль орчны газар, Аймгийн Засаг даргын 2014 онд А/42 дугаар захирамжаар Байгаль орчин аялал жуулчлалын газар болж, дарга, 6-н мэргэжилтэн, нягтлан бодогч, нярав-жолооч, 28 байгаль хамгаалагчийн орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймаг дахь Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 614,402.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,144.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,300.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган аймаг дахь Байгаль орчин, аялал жуулчлалын газар 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 52,142.0 мянган төгрөгөөр буюу 6.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,108.9	0.0	(1,108.9)
Бараа материал	78,918.32	77,061.02	(1,857.3)
Үндсэн хөрөнгө	748,663.9	696,521.9	(52,142.0)
Нийт хөрөнгө	828,691.14	773,582.92	(55,108.22)
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	828,691.14	773,582.92	(55,108.22)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	828,691.14	773,582.92	(55,108.22)

Бараа материалын данс 77,061.02 мянган төгрөг болж 1,857.3 мянган төгрөгөөр буурсан. Бараа материалыг өртгөөр нь бүртгэж эхэлж авснаа эхэлж зарлагадах аргаар тайланд тусгасан. Байгаль хамгаалах сангаас 3,173.5 төгрөгийн үнэ бүхий тараах материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэн авсан. 6,232.14 төгрөгийн бараа материалыг байгууллагын даргын 2021.12.21-ний өдрийн А/85 тоот тушаалаар акталж данснаас хассанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 696,521.9 мянган төгрөг болж 52,142.0 мянган төгрөгөөр буурсан. Орон нутгийн төсвийн санхүүжилтээр 33,500.0 төгрөгийн үнэтэй Сентон маркийн уурын зуух худалдан авсныг үндсэн хөрөнгөнд бүртгэн авсан. 2021.12.21-ний өдрийн А/86 тоот тушаалаар цаашид ашиглах боломжгүй 2,410.6 төгрөгийн үндсэн

хөрөнгийг акталж данс бүртгэлээс хасан ажиллалаа. Байгууллагын даргын 2021 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн А/87 тоот тушаалаар байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хийсэн, тооллогоор дутагдсан хөрөнгө байхгүй болно.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 773,582.92 мянган төгрөг болж 55,108.22 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Булган аймаг дахь Байгаль орчин, аялал жуулчлалын газар санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 61,632.15 мянган төгрөгөөр буюу 9.1 хувиар буурсан, нийт зардал өмнөх оноос 87,308.1 мянган төгрөгөөр буюу 14.94 хувиар өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Булган аймаг дахь Байгаль орчин аялал жуулчлалын газар 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 984,963.63 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 984,963.63 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 381,561.33 мянган төгрөгөөр бууруулан 603,402.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх мэргэжлийн боловсрол хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр 603,402.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, нэмэлт орлогоос 10,050.0 мянган төгрөг, урсгал үйл ажиллагаанд 599,437.2 мянган төгрөгийг зарцуулж, 14,015.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 599,437.2 мянган төгрөг буюу 98.4 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 5,161.0 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2,280.1 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардлыг 960.9 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг 5,545.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн зардлыг 67.2 мянган төгрөгийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 10,900.0 мянган төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 150.0 мянган төгрөг санхүүжилт орж ирсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Булган аймаг дахь Байгаль орчин аялал жуулчлалын газар нь 2021 онд нийт 603,402.3 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй 149 талбарыг хуулийн хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна. Шатахууны гэрээний дагуу олгодог 332.9 мянган төгрөгийн шатахууны урамшууллыг орлогод авч бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.5-д "Нягтлан бодох бүртгэлд бүх орлогыг заавал бүртгэнэ" заалтын дагуу үнэ төлбөргүй орлогод бүртгэх

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 70.4 мянган төгрөгийн 2 акт, 11,008.8 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/ Мян.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	2	70.4	2	70.4	-	-	
Албан шаардлага					-	-	
Зөвлөмж	2	11,008.8	2	11,008.8	-	-	
Нийт дүн	4	11,079.2	4	11,079.2	-	-	

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар нэмэлт санхүүжилтийн дансаар, орсон санхүүжилтээр гарсан зардал тухай бүрт нь тайлагнаагүй бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс дансанд тайлагнаж байна. Цаашид зардлыг Сангийн сайдын 2021 оны 190 тушаалаар батлагдсан “ Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар ” журмын дагуу бүртгэж тайлагнахад анхаарах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 399.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 67.0 мянган төгрөгийн 1 акт, 332.96 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Тайлант хугацаанд залруулсан алдаа байхгүй.

4.2 Албан шаардлага

Тайлангийн хугацаанд албан шаардлага байхгүй.

4.3 Акт

Бараа материалын тайлан болон шаардах хуудас тамга, тэмдгээр баталгаажуулахгүй, зарим анхан шатны баримтын иж бүрдэл дутуу гүйлгээ хийгддэг байна. 67.0 мянган төгрөг анхан шатны баримтгүй гүйлгээ хийгдсэн байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн акт:

Цахим баримтаар гүйлгээг хийж хэвших, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.2. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө нөхсөн тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа болон ашиглагдаж байгаа 35 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь УСНББОУС үндсэн хөрөнгө 17-ийн 49 Дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээс материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай " гэсэн заалтын дагуу дахин үнэлгээ хийх шийдвэрийг гаргуулан дахин үнэлгээг хийлгэн санхүүгийн тайланд тусгаж байх гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.3. Өгсөн зөвлөмж:

Шийдвэр гаргуулан тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа хөрөнгийг заавар журмын дагуу актлуулах саналыг гаргуулан акталж устгах.

2. Орлогын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Шатахууны гэрээний дагуу олгодог 332.9 мянган төгрөгийн шатахууны урамшууллыг орлогод авч бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.5-д "Нягтлан бодох бүртгэлд бүх орлогыг заавал бүртгэнэ" заалтыг мөрдөөгүтэй холбоотой байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг цуглуулж төвлөрүүлэн, үнэ төлбөргүй орлогоор санхүүгийн тайланд бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/


Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	БОАЖ газар	3	399.9	-	-	1	67.0			2	332.9
	Дүн	3	399.9	-	-	1	67.0			2	332.9

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

"БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ" ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР:



Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ:




Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:



Ж.ЭНХЦООДОЛ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Д.АНХБАЯР